

АЗИЙН ХӨГЖИМ СУДЛАЛЫН ОЛОН УЛСЫН ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ БОЛОМЖИЙН ТУХАЙ

(Асуудал дэвшүүлсэн өгүүлэл)

*Ж.Энэбиш**

Хөгжим-энэрэнгүй үзэл, энхийн
уриаг түгээн тунхаглагч, эвдрэлийн
салхийг үлдэн хөөгч мөн.

Би энэхүү өгүүлэлд зүүн Азийн өргөн удам нутагт өнө удаан жил оршин тогтож ирсэн улс үндэстнүүдийн хөгжмийн соёлын угсаа гарвал, харилцаа холбоо, харилцан нөлөөлөл, нүүдэл тархачын асуудлыг олон улсын эрдэмтдийн судалгааны бүтээлийн үр дүнд тулгуурлан судлах арга судлалын зарим асуудлыг дэвшүүлэн тавих гэсэн юм. Олон улсын хөгжим судлаачдын хамтын оюунаар судлах бодтой үр дүнд хүрч болох тийм сэдэв бол миний бодлоор **хөгжмийн зэмсэг судлал** байж болно. Яагаад гэвэл, бийваа¹, ятга², ёочин³, хуучир⁴, шударга⁵, лимбэ⁶, бишгүүр⁷ гэх мэтийн хөгжмийн зэмсгүүд Монгол, Хятад, Япон, Солонгос, Вьетнам зэрэг зүүн Азийн улс орнуудын хөгжмийн амьдралд түгээмэл хэрэглэгдсээр байгаа билээ. Энэ бол бидний хэрэгжүүлэхийг зорьж буй хөгжим судлалын олон улсын төслийн сэдэв бэлэн, төсөлд хамрагдах улс орнууд тодорхой байна гэсэн үг юм.

Харин хөгжим судлалын олон улсын төслийн багийг хэрхэн бүрдүүлэх, судалгааны үзэл баримтлал, аргагүйг хэрхэн боловсруулах тухай асуудал бол тийм ч хялбар биш нь мэдээж. Миний бодлоор бол судалгаанд хамрагдсан улс орнуудын хөгжим судлаач-эрдэмтэд хөгжмийн зэмсэг тус бүрээр олон улсын баг бүрдүүлж ажиллавал илүү үр дүнд хүрч болох мэт санагдана. Асуудлыг ингэж үзэх аваас, Хөгжим судлалын олон улсын төсөлд юуны өмнө бийваа, ятга, ёочин, хуучир, шударга, лимбэ, бишгүүр судлаач 30-40 эрдэмтэн оролцох боломж бүрдэнэ. Эдгээр эрдэмтдийг сонгож оролцуулах асуудал ч төвөгтэй биш. Яагаад гэвэл дээр нэг дурдсан хөгжмийн зэмсгийг дагнан судалсан эрдэмтэд, төсөлд оролцогч улс орнуудад бэлхэнээ байгаа. Энэ бол хамтын төсөл хэрэгжүүлэхийн хүн хүчний чухал нөөц мөн.

*Жамбалын Энэбиш - Монгол Улсын угсаатны хөгжим судлаач, урлаг судлалын ухааны доктор, профессор, Соёл урлаг судлалын хүрээлэнгийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, Уламжлалт хөгжмийн олон улсын зөвлөлийн гишүүн /ICTM/.

Үүнээс гадна БНХАУ-ын Шанхай хотын их сургуулийн хөгжмийн профессор Чен Инши, Япон улсын Токиогийн их сургуулийн хөгжмийн профессор Сато Ёошиаки, БНСУ-ын Ханянийн их сургуулийн хөгжмийн профессор Kwon Oh-sung, түүний шавь Пак Су Хён нар монголын уламжлалт хөгжмийг сонирхон судалж байгаа явдал хөгжим судлалын олон улсын төсөл хэрэгжүүлэх үйл ажиллагаанд урам хайрлаж хүч нэмэгдүүлж байна. Эдгээр эрдэмтэд хөгжим судлалын олон улсын төслийн багийн гишүүдийг бүрдүүлэх, төслийн үзэл баримтлал, нэгдсэн аргазүйг боловсруулахад идэвхитэй оролцож хамтран ажиллана гэдэгт монголын хөгжим судлаачид бүрэн итгэлтэй байна.

Одоо би хөгжим судлалын олон улсын төслийн зорилго болон юуг яаж судлаж ямар үр дүн гаргах гээд байгаа тухай саналаа хэлье. Хөгжим судлалын олон улсын төслийн зорилгыг би хувьдаа: Зүүн Азийн олон арван улс орныг дамжиж тархсан адил төстэй хөгжмийн зэмсгүүдийн үүх түүх, угсаа гарвал, материалын сонголт, хийц бүтэц, хөгжмийн зэмсэг тус бүрийн хөг хөгөлгөө, өнгө будаг, хөгжимдөх арга барил, илэрхийлэх дүрслэх боломж, өвлөн тээгчдийн ур чадвар, хөгжимдөх донж маяг, улс үндэстний хөгжмийн сэтгэлгээний онцлогийг нэгдсэн аргазүйн дагуу харьцуулан судалж тэдгээр хөгжмийн зэмсгийн хөгжил, соёл түүхийн түгээмэл зүй тогтолыг нээгдүүлэхэд оршино хэмээн төсөөлж байна. Төслийн нэгдсэн аргазүйг хөгжим судлалын олон улсын төслийн багийн гишүүд тус тусдаа буюу хамтарч боловсруулж болно. Харин үүний дараа баг тус бүр судалгаанд хамрагдсан улс орнуудад очиж судалгаа хийнэ. Судалгааны ажлын явц, үр дүнг уулзалт, ярилцлага, эрдэм шинжилгээний хурал, хөгжмийн наадмын хэлбэрээр тухайлсан улс орнуудад ээлж дараалан хийж болно.

Хөгжим судлалын олон улсын төслийн үр дүнг эрдэм шинжилгээ, уран бүтээл гэсэн хоёр хэлбэрээр тооцох санал байна. Эрдэм шинжилгээний хэсэгт төсөлд хамрагдсан улс орнуудын хөгжмийн зэмсэг тус бүрийн харьцуулсан судалгааны хамтын бүтээлүүд үндэстэн бүрийн төрөлх хэлээр судалгаанд хамрагдсан улс орнуудад нэгэн зэрэг хэвлэгдэнэ. Уран бүтээлийн хэсэгт төсөлд хамрагдсан ижил төрлийн хөгжмийн зэмсгүүдээс бүрдсэн олон улсын ардын найрал хөгжим байгуулж болно. Олон улсын ардын найрал хөгжим буй болсноор төсөлд оролцогч улс орнуудын хөгжмийн шилдэг бүтээлийг хөгжимдөх, уран бүтээлчид харилцан туршлага солилцох боломж нээгдэнэ. Энэ

бүхэн нь зүүн Азийн улс орнуудын хөгжмийн соёлын харилцан ойлголцох, харилцан баяжих үйл явцад жинтэй хувь нэмэр оруулах ач холбогдолтой байж болох юм. Үүнчлэн энэ төслийн үзэл санаа арга зүйг зөвхөн Зүүн Азид⁸ төдийгүй Дундад Ази⁹, Баруун Азийн¹⁰ улс орнуудын адил төрлийн хөгжмийн зэмсгүүдийг судлахад ч ашиглаж болно.

Хөгжим судлалын олон улсын төсөл хэрэгжүүлснээр дорно дахины улс үндэстнүүд хөгжмөөр эв нэгдэл нөхөрлөлийн бат цайз босгож, бие биесийнхээ соёл, зан заншлыг харилцан хүндэтгэж, амар жимэр аж төрөх боломж улам батжина.

Тайлбар

№	Монгол	Хятад	Солонгос	Вьетнам	Япон
1	Бийваа	Pipa	Bipa	Tiba	Biwa
2	Япта	Zheng	Kayagum	Tam thap luc	
3	Ёочин	Yangqin	Yanggum	Dan tranh	
4	Хуучир	Erhu	Haegum	Dan nhi	
5	Шударга	Sanxian			
6	Лимбэ	Dizi	Taegum	яао	
7	Бишгүүр	Suona	Taeryogso	Кён	

8. Монгол, Малайз, Сингапур, Хятад, Япон, Солонгос, Бангладеш,

Бирм, Тайланд, Вьетнам, Кампучи, Лаос, Индонез, + Филиппин

9. Узбек, Казах, Киргиз, Тажик, Туркмен

10. Инди /Энэтхэг/, Пакистан, Афганистан, Иран, Ирак